



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/186

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Төсвийн тухай хуулийн 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас баталсан "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" зорилтын хүрээнд "Үндэсний болон орон нутгийн онцлогтой хоол, ундааг хөгжүүлэх нь" сэдэвт зүүн бүсийн аймгуудын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын аварга шалгаруулах сургалт, арга хэмжээ Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод зохион байгуулагдахтай холбогдуулан 264600 /хоёр зуун жаран дөрвөн мянга зургаан зуун/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 976

Аймгийн Засаг даргын 2017 оны
05 дугаар сарын 11 өдрийн 41186
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэрс	Хэмжих нэгж	Шаардагдах хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Бензин	Литр	90	1540	138600
2	Дизель түлш	Литр	70	1800	126000
Нийт үнэ					264600